<p>2.2.14. Геологийн судалгаа, хайгуулын ажлын үр дүнг нэгтгэн боловсруулж, үндэсний геомэдээллийн санг баяжуулна. Мэдээлэл түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгоно.</p> <p>- Төслийн 2016 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн болон анхдагч баримт материалыг хүлээн авна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Хүлээн авсан байна. Хугацаа: 4-р улирал</p>	<p>2016 оны ажлын төлөвлөгөө, төсвийг УУХҮС-ын 31 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн ажлын арга аргачлал, хэмжээ, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцэж шийдвэрлэсэн. Төслийн 2016 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн болон анхдагч баримт материалыг хүлээн авах комиссд ажиллаж санал өгсөн. Ажлын явц, үр дүн болон санхүүжилтийн асуудлаас шалтгаалан төслийг 2017 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.</p>	30	
<p>2.2.15. Монгол орны баруун бүсэд цул сульфидын хүдэржилтийн тархалтыг 1:1000000-ын масштабын хэтийн төлөвийн зураг зохиох, үнэлгээ өгөх, цаашдын судалгааны объектыг тодруулах төсөл хэрэгжүүлнэ.</p> <p>- Төслийн 2016 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн болон анхдагч баримт материалыг хүлээн авна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Хүлээн авсан байна. Хугацаа: 4-р улирал</p>	<p>2016 оны ажлын төлөвлөгөө, төсвийг УУХҮС-ын 31 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн ажлын арга аргачлал, хэмжээ, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцэж шийдвэрлэсэн. Төслийн 2016 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн болон анхдагч баримт материалыг хүлээн авах комиссд ажиллаж санал өгсөн. Ажлын явц, үр дүн болон санхүүжилтийн асуудлаас шалтгаалан төслийг 2017 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.</p>	30	
<p>3.0. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХУВИЛБАР, ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:</p>			
<p>3.1. Уул уурхайн салбарыг хөгжүүлэх хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:</p>			
<p>3.1.2. Уул уурхайн салбарт мөрддөг дүрэм журмыг шинэчилэн боловсруулах.</p> <p>-“Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулна.</p> <p>- “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг боловсруулна.</p> <p>-“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж батлуулна.</p> <p>- Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журмыг шинэчлэн боловсруулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Дүрэм боловсруулж батлуулсан байх Хугацаа: 4-р улирал</p>	<p>Уул уурхайн тухай хууль боловсруулах ажлын хэсэг байгуулагдан олборлох, баяжуулах, боловсруулах, зэрэг ашиглалтын бүх үйл ажиллагааг цогцоор нь эрх зүйн хувьд шийдвэрлэхээр ажиллаж байна. Энэхүү ажлын хэсгийн нэг үндсэн зорилго нь дурьдсан олон тооны дүрэм журам, заавруудыг нэгтгэн уялдуулах зорилготой байгаа тул эдгээр төслүүдийг түр хойшлуулсан байна.</p>	30	
<p>3.1.3. “Нүүрс” хөтөлбөрийг боловсруулна.</p> <p>- Хөтөлбөрийг төслийг боловсруулж, хэлэлцүүлэг явуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Төсөл боловсруулагдсан байна. Хугацаа: 4-р улирал</p>	<p>Нүүрсний олборлолт, борлуулалт, экспортын өнөөгийн байдлын талаар танилцуулга бэлтгэх, “Нүүрс хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах, холбогдох судалгааг хийх, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэх, хөтөлбөрийн танилцуулгыг шинэчлэх ажлууд хийгдэж байна</p>	21	
<p>3.1.4. “Жонш” хөтөлбөрийг боловсруулна.</p> <p>- Хөтөлбөрийг төслийг боловсруулж, хэлэлцүүлэг явуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Төсөл боловсруулагдсан байна. Хугацаа: 4-р улирал</p>	<p>“Жонш” хөтөлбөрийн төслийг шинэчлэн боловсруулж, удирдлагад танилцуулсан. Хөтөлбөрийн төслийг холбогдох журамд нийцүүлэн, хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөж байна.</p>	21	

<p>3.1.5. “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын зарчмыг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангана. -“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын зарчмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Зарчим хэрэгжиж эхэлсэн байна. Хугацаа: 4-р улирал</p>	<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын албатай хамтран ажиллаж Гэрээний ил тод байдлыг хангах Дэд ажлын хэсгийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын зарчмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд төрийн болон иргэний нийгмийн байгууллага /Нээлттэй нийгэм форум, Хил хязгааргүй алхам ТББ г.м/-тай хамтран ажиллаж байна.</p>	27	
<p>3.2. Ашигт малтмалын ордуудыг олборлох, баяжуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг зохицуулах болон ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:</p>			
<p>3.2.1. Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. - Оюутолгой, Тавантолгой, Цагаансуварга, Гацуурт зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: 4 удаа, Чанар: Холбогдох асуудал шийдвэрлэгдсэн байх, Хугацаа: 4-р улирал</p>	<p>Оюутолгой, Тавантолгой, Цагаансуварга, Гацуурт зэрэг стратегийн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Тухайлбал: Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт буюу төслийн 2 дахь шатны ажлыг эхлүүлж, туслан гүйцэтгэгч “РедПат” ХХК-д тэсэлгээний тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. -Японы Нагата Инженеринг компанитай хамтран Эрдэнэс Тавантолгойн уурхайн нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтыг хийлгэсэн. - Цагаансуваргын ордыг ашиглалтад оруулахад шаардлагатай цахилгаан хангамжийн асуудлаар ЭХЯ, холбогдох байгууллагатай хамтран ажилласан. Гацууртын ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголд шүүмж дүгнэлт гаргаж, дүнг сайдад танилцуулан ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.</p>	30	
<p>3.2.2. Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах төслийн талаар санал боловсруулна. - Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах оновчтой хувилбарын талаар санал боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Холбогдох асуудал шийдвэрлэгдсэн байх. Хугацаа: 4-р улирал</p>	<p>-Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглах 3 хувилбар бүхий санал боловсруулж, яамны удирдлага /Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга/-д танилцуулсан. Ордыг олон улсын концерциумтай хамтарсан хэлбэрээр ашиглах нь оновчтой гэсэн санал гаргасан бөгөөд нэгэнт бий болсон үйлдвэр, дэд бүтцийг шууд ашиглах, Хятадын зах зээлд нэвтэрч бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн ханшаар борлуулах, гуравдагч зах зээлд гарах боломж бүрдэх, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, урьд хийсэн яриа хэлэлцээг үр дүнд хүргэх боломжтой гэж үзсэн. -Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглахтай холбогдон, Уул уурхайн яам /Эрдэнэс тавантолгой ХК/ болон Япон улсын НЕДО байгууллага /Нагата инженеринг/ хамтран Тавантолгойн ордыг түшиглэн нүүрсийг хуурай аргаар баяжуулах туршилтын үйлдвэр байгуулах тухай санамж бичгийг байгуулсан ба уг төслийн ажлыг тус яам үргэлжлүүлж байна. -Яам болон уг төслийг хэрэгжүүлж буй Эрдэнэс монгол ХХК хооронд хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан, төслийн талаар танилцуулга бэлтгэн Дэд сайд болон ТНБД, хуулийн хэлтэст танилцуулж, гэрээг байгуулав. -12 сарын 07-ны өдөр Японы НЕДО байгууллага, Нагата инженеринг компанийн төлөөллийг хүлээн авч уулзан, санамж талаар болон төслийн явцын талаар харилцан санал солилцсон. -Санамж бичиг болон, цаашдын хамтын ажиллагааны талаар санал, албан тоотыг НЕДО руу хүргүүлэв. -Уг төслийн үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх талаарх хууль эрхзүйн орчны судалгааг хийж Сангийн яам болон Татварын ерөнхий газарт санал боловруулж хүргүүлэхээр бэлтгэсэн</p>	30	

<p>3.2.3. Оюутолгойн ордын далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>- Оюутолгойн далд уурхайн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Холбогдох асуудал шийдвэрлэгдсэн байх, Хугацаа: 4-р улирал</p>	<p>-Оюутолгой төслийн далд уурхайн бэлтгэл ажлыг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, “Оюутолгой” ХХК-ийн туслан гүйцэтгэгч “Ред Пат” ХХК-д тэсэлгээний тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд оролцож, төслийн 2 дахь шатны үйл ажиллагааг эхлүүлсэн.</p> <p>-Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ханган нийлүүлэгч “Максам эксплозивс” ХХК-ийн босоо ам нэвтрэлтийн эмульсийн тэсрэх бодис цэнэглэгч төхөөрөмжийг байнгын ашиглалтад хүлээн авсан.</p> <p>-Босоо ам нэвтрэлтийн туслан гүйцэтгэгч “Рефпад Монголиа” ХХК-ийн камер байгуулахад зориулсан анфо цэнэглэгч төхөөрөмжийг байнгын ашиглалтад хүлээн авсан.</p>	30	
<p>3.2.4. Цагаансуварга төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>- Цагаансуваргын уурхай, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Холбогдох асуудал шийдвэрлэгдсэн байх, Хугацаа: 4-р улирал</p>	<p>“Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэр”-ийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж хийх шинжээчдийн хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны А/62 дугаар тушаалаар байгуулан ажлын хэсгийг ахлан ажиллаж, шинжээчдийн нэгдсэн дүгнэлтийг гаргаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p>	30	
<p>3.2.5. Гацууртын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>- Гацууртын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй Орд ашиглах гэрээ байгуулах яриа хэлэлцээрийг эхлүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Яриа хэлэлцээр үр дүнтэй байх, Хугацаа: 4-р улирал</p>	<p>Гацууртын ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголд шүүмж дүгнэлт гаргаж, дүнг яамны удирдлагад танилцуулсан. Ордын нөөцийн ангиллыг шинэчлэн тогтоосноор ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх боломжтой гэж үзсэн. ТЭЗҮ-ийг хэлэлцэж хүлээж авсны дараа Орд ашиглах гэрээ байгуулах талаар яриа хэлэлцээрийг эхлүүлэхээр ажиллаж байна.</p>	27	
<p>3.2.6. Тавантолгой, Нарийнсухайтын нүүрсний ордод тулгуурлан цахилгаан станц барихад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>- Тавантолгой, Нарийнсухайтын нүүрсний ордод тулгуурлан цахилгаан станц барихад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Холбогдох асуудал шийдвэрлэгдсэн байх Хугацаа: 4-р улирал</p>	<p>Уг ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй 3 удаа уулзалт зохион байгуулж Тавантолгойн цахилгааны станцын талаар санал солилцсон. Танилцуулгыг бэлтгэж удирдлагад танилцуулсан.</p>	21	
<p>3.2.7. Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>- Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>-Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ашигт малтмалын орд ашиглах /уурхай, уулын үйлдвэрийн/ техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх салбар хуралдааныг 3 удаа зохион байгуулж, холбогдох шийдвэрийг гаргахад оролцсон.</p> <p>-Төв аймгийн Баян сумын нутагт орших “Эрдэнийн Цахирмаа Тал” ХХК-ийн Булагтайн алтны шороон ордын ил уурхайг ашиглалтад хүлээн авах Улсын комиссыг ахалж ажилласан. Компанид тодорхой зарим асуудлаар хугацаатай албан даалгавар өгч, биелэлтийг хангуулсаны үндсэн дээр уурхайг хүлээн авах шийдвэр гаргасан.</p> <p>-Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших “Шинь шинь” ХХК-ийн Улааны холимог металлын уурхайг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комиссыг ахалж ажилласан. Энэ үеэр уурхайн үйл ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p>	30	

Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Ашиглалтанд оруулсан байх, Хугацаа: 4-р улирал	-Төв аймгийн Заамар сум, Булган аймгийн Бүрэгхангай сумдын нутагт орших алтны шороон ордыг ашиглах алтны уурхайг байнгын ашиглалтад хүлээж авах Улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан		
4.0. ТҮЛШ, ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХУВИЛБАР, ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:			
4.1. Түлш, газрын тосны салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:			
4.1.1. Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журмыг шинэчлэн найруулна. - Журмыг шинэчлэн найруулах төслийг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэнэ. Тоо хэмжээ: 1, Чанар: Төслийг боловсруулсан байна. Хугацаа: 4-р улирал	Журмыг шинэчлэн найруулах төслийг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгээд байна.	15	
4.1.2. Хийн түлшний тээвэрлэлт, хадгалалт, түгээлт, борлуулалтад тавих стандарт, дүрэм, журмыг шинэчлэн боловсруулна. - Хийн түлшний олон улсын NFPA-58 стандартыг орчуулан үндэсний стандартын төсөл боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар:Төслийг боловсруулсан байна. Хугацаа: 4-р улирал	Шингэрүүлсэн шатдаг хийн түлшний хэрэглээ, хангамж, нийлүүлэлттэй холбогдсон норм, дүрмийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 110 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг гурван удаа хуралдсан бөгөөд АНУ-ын NFPA-58 стандартыг орчуулав. 2016 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн албан тоотоор АМГТГ-т орчуулгын төслийг хүргүүлэн үндэсний стандартын төсөл боловсруулж ирүүлэхийг даалгасан. “Шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээний аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн төслийг боловсруулж бэлэн болгосон.	15	
4.2. Газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах бодлогыг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:			
4.2.1. Газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг эрчимжүүлнэ. - Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар сонгон шалгарсан аж ахуйн нэгжийн Бүтээгдэхүүн хуваах гэрээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн зохих шийдвэр гаргуулна.	Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар сонгосон шалгарсан дараах ААН-ийн асуудлыг шийдвэрлүүлээд байна. Үүнд: Газрын тосны Дарьганга XXIV талбайд ГТГ /хуучин нэрээр/ болон “Апекспро инвестмент лимитэд” ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээгээр гэрээлэгчийн хүлээсэн эрх, үүргийг “Монголиа шин ий энерги” ХХК-д шилжүүлэх тухай асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн 2016-1-11-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлсэн. - Газрын тосны хайгуулын “Ар булаг-29” талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах эрх олгох асуудлаар бүх яамдаас санал аван Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 41 тоот тогтоолоор шийдвэрлүүлсэн. -Газрын тосны хайгуулын Тариач-15 талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах эрх олгох Засгийн газрын тогтоолын төсөлд яамдын санад авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2015 оны 11 дүгээр сарын 02-ны 431 тоот тогтоолоор шийдвэрлүүлэв. -Газрын тосны Эргэл XII талбайд АМГТГ болон “Smart oil investment LTD” компанийн хооронд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн 2016-8-24-ний өдрийн 53 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. - Газрын тосны хайгуулын “Богд-IV”, “Онги-V” талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг буцаан шилжүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр 01/866	30	

<p>- Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, компанид шинээр батлагдсан хуульд нийцүүлэн тусгай зөвшөөрлийг шинэчлэх арга хэмжээг авна.</p> <p>- Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд бодлогоор дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.</p> <p>- Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ97 гэрээт Зүүнбаян XIII, Цагаан-элс XIV талбайн олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд бодлогоор дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.</p> <p>- Газрын тосны хайгуул, ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаан явуулж буй ААН-үүдийн ажиллах хүчний асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, Хөдөлмөр,</p>	<p>тоотоор хүргүүлж, 2016 оны 12 –р сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 181 тоот тогтоолоор шийдвэрлүүлсэн.</p> <p>Шинээр батлагдсан хуульд нийцүүлэн тусгай зөвшөөрлийг шинэчлэх ажлын хүрээнд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Тосон Уул-19”, “Тамсаг-21”, “БХГ 97” талбайнуудын гэрээлэгч “Петрочайна дачин тамсаг”, “Доншен газрын тос Монгол” ХХК-д ашиглалтын тусгай зөвшөөрөл олгов.</p> <p>Газрын тосны Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд үйл ажиллагаа явуулж Петрочайна Дачин Тамсаг ХХК-д Уул уурхайн сайдын /хуучин нэрээр/ а/61 дүгээр тушаалаар аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 8 жилийн хугацаагаар олгосон.</p> <p>Газрын тосны Дарьганга XXIV талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “Алекспро инвестмент лимитэд” ХХК-д Уул уурхайн сайдын /хуучин нэрээр/ а/72 дугаар тушаалаар аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 8 жилийн хугацаагаар олгосон.</p> <p>Засгийн газрын 2015 оны 104-р тогтоолоор батлагдсан “бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар”-т нийцүүлэн өмнө байгуулсан гэрээнүүдийг шинэчлэх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/57 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт ажиллаж, хэлэлцээрийг 2016-12-14-ны өдөр эхлүүлэн, үргэлжлүүлэн ажиллаж байна.</p> <p>Шинээр батлагдсан хуульд нийцүүлэн тусгай зөвшөөрлийг шинэчлэх ажлын хүрээнд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Тосон Уул-19”, “Тамсаг-21”, “БХГ 97” талбайнуудын гэрээлэгч “Петрочайна дачин тамсаг”, “Доншен газрын тос Монгол” ХХК-д ашиглалтын тусгай зөвшөөрөл олгов.</p> <p>Газрын тосны Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд үйл ажиллагаа явуулж Петрочайна Дачин Тамсаг ХХК-д Уул уурхайн сайдын /хуучин нэрээр/ а/61 дүгээр тушаалаар аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 8 жилийн хугацаагаар олгосон.</p> <p>Газрын тосны Дарьганга XXIV талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “Алекспро инвестмент лимитэд” ХХК-д Уул уурхайн сайдын /хуучин нэрээр/ а/72 дугаар тушаалаар аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 8 жилийн хугацаагаар олгосон.</p> <p>Засгийн газрын 2015 оны 104-р тогтоолоор батлагдсан “бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар”-т нийцүүлэн өмнө байгуулсан гэрээнүүдийг шинэчлэх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/57 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт ажиллаж, хэлэлцээрийг 2016-12-14-ны өдөр эхлүүлэн, үргэлжлүүлэн ажиллаж байна.</p> <p>УУЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД-ын 81 дүгээр тушаалаар Дорнод аймгийн Халхгол сумын нутагт 2013-2015 оны хооронд Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тамсаг XXI талбайн олборлолт нэмэгдүүлэх цооногийн байгууламж, 2013 оны тосны цооног 51ш, усны цооногийн байгууламж 11ш, 2014 оны тосны цооног 52 ш, усны цооногийн байгууламж 18ш, 7000м³-ын сав 2ш, гүний ус цэвэршүүлэх станц, бохир ус цэвэршүүлэх станц, 2015 оны тосны 105ш цооног, усны цооногийн байгууламж 49ш, 7000м³-ын сав 1ш, ус, тос ялгах байгууламж болон холбогдох барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст 2016 оны 6-р сард ажиллаж, байгууламжийг хүлээн авсан.</p> <p>-УУХҮЯ-ны ТНБД-ын Б/55 дугаар тушаалаар Дорнод аймгийн Матад сумын нутагт 2013-2015 оны хооронд Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон-Уул XIX талбайн олборлолт нэмэгдүүлэх цооногийн байгууламж (2013 оны тосны цооног 47ш, усны цооног 22ш, 2014 оны тосны цооног 43 ш, 2015 оны тосны цооног 59ш, усны цооног 7 ш, 6ш тосны цооногийг ус шахалтын цооног болгон өөрчлөх), ТА19-91 үйлдвэрлэлийн хяналтын өрөөний инженерчлэл, ТА1-11 шинээр барих тос буулгах байгууламж, 1-9 тос дамжуулах станцын өргөтгөл, ТА-1-ийн шинэ ачилтын талбайг ашиглалтад оруулах комиссыг ажиллуулах, ажлыг 2016-10-р сард зохион байгуулж, байгууламжийг хүлээн авсан.</p>		
---	--	--	--

<p>нийгмийн хамгааллын яаманд тухай бүр уламжлан шийдвэрлүүлнэ. Тоо хэмжээ: 1удаа, Чанар:Хууль тогтоомжид нийцсэн байна. Хугацаа: 4-р улирал</p>	<p>2016 онд байдлаар газрын тосны хайгуул, ашиглалтын 2016 оны үйл ажиллагаанд зориулан “Петрочайна дачин тамсаг”, “Эн Пи Ай”, “Капкорп монголиа”, “Импайр газ Монголиа” зэрэг компаниудын гадаадаас авах ажиллах хүчний асуудлыг журмын дагуу Уул уурхайн сайдын /хуучин нэрээр/ 2016.05.30-ны 1/993 тоот бичгээр Хөдөлмөрийн яаманд уламжлан шийдвэрлүүлсэн.</p> <p>-“ газрын тосны хайгуул, ашиглалтын 2016 оны үйл ажиллагаанд зориулан “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн 990, “Эн Пи Ай” 358, “Импайр газ Монголиа” 100, Увс I талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “Монголиа Гладвилл Увс петролеум” компанид 4 гадаад мэргэжилтэн авах хүсэлтийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 8-р сарын 16-ны өдрийн 1/60 тоот бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд уламжлан шийдвэрлүүлсэн.</p> <p>-“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 1160, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 64, нийт 1224 гадаад ажиллах хүч, мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлхээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд 2016-12-12-ны өдрийн 01/1048 тоот албан бичгээр уламжилсан.</p>		
<p>4.2.2. ОХУ-аас бусад орноос импортлох авто бензин, дизель түлшний хэмжээг нэмэгдүүлнэ. - ОХУ-аас гадна БНХАУ болон гуравдагч орнуудаас автобензин, дизель түлш импортлох асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана. Тоо хэмжээ: 5, Чанар: Бусад орноос импорт хийгдсэн байна. Хугацаа: 4-р улирал</p>	<p>Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2012 онд 1.3 сая тн, 2013 онд 1.4 сая тонн, 2014 онд 1.3 сая тонн автобензин, дизелийн түлш импортлосон бол 2015 онд 1.1 сая тонн, 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт 422,582 тонн бүтээгдэхүүн импортлосон ба 93 хувийг ОХУ-аас, 0.7 хувийг БНХАУ-аас, 5.9 хувийг БНСУ-аас үлдсэн хувийг Литва, Сингапур зэрэг бусад улсаас импортолж байна. БНХАУ-ын “Чайна-Ойл” компанитай хэлэлцээр хийж, гэрээ байгуулах асуудлыг зохион байгуулснаар сар бүр 4000-10000 тонн газрын тосны бүтээгдэхүүн авч байна. Мөн ОХУ-ын ДИТЭКО, ТНК-БП, Газпром, ОРСК, Газпромсалават, Тайф болон бусад компаниудаас үлдсэн хэсгийг импортолсон. БНХАУ-ын UNIPES-тэй газрын тосны салбарт хамтран ажиллах асуудлаар санамж бичиг байгуулахаар үргэлжлүүлэн ажиллаж байна. БНХАУ-ын талд санал тавьсан боловч өнөөг хүртэл хариу ирүүлээгүй.</p>	30	
<p>4.2.4. Газрын тосны бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах зорилтын хүрээнд бусад орны сайн туршлагыг импортлогч компаниудтай хамтран судалж, компаниудад боломжит дэмжлэг үзүүлнэ. - Газрын тосны бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Импортлогч компаниудад дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: 4-р улирал</p>	<p>Алслагдсан аймаг, сумдын шатахууны үнийг бууруулж төвийн бүсийн үнийн түвшинд хүргэж улс даяар ойролцоо үнэтэй болгох ажлын хүрээнд холбогдох тооцоо судалгааг хийсэн. Засгийн газрын 438 дугаар тогтоолоор баруун, зүүн, төвийн бүсүүдэд шатахууны Онцгой албан татварыг ялгавартай тогтоож, баруун болон зүүн бүсийн шатахууны жижиглэнгийн үнийг төвийн бүсийн үнэтэй ижил түвшинд хүргэсэн. Гэвч хилийн үнийн хэлбэлзэл болон төгрөгийн ханшийн суларлаас хамааран жижиглэн борлуулалтын үнэ нөлөөлөх хэмжээнд хүрсэн бөгөөд одоогоор 2016 оны Засгийн газрын 109, 166 дугаар тогтоолоор тус тус үнэ тогтворжуулах арга хэмжээ аваад байна.</p>	30	
<p>4.3. Био болон эко, алтернатив түлшний үйлдвэрлэл, түлшний чанар стандарт, агаарын бохирдлыг бууруулах бодлогыг төлөвлөх, боловсруулах, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:</p>			

<p>4.3.1. Түлш, газрын тосны бүтээгдэхүүний стандартыг олон улсын жишигт нийцүүлэх талаар судалгаа хийж хэрэгжүүлэх</p> <p>- Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний стандартад нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулна.</p> <p>- Түлш, газрын тосны бүтээгдэхүүний стандартад нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналын төслийг Стандартчлал хэмжил зүйн газраар хэлэлцүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Хэлэлцүүлсэн байна. Хугацаа: 4-р улирал</p>	<p>Экспортын нүүрсний олборлолт, борлуулалтын мэдээ, тайланг 7 хоног, сар, улирал, жилээр Ашигт малтмалын газрын /хуучин нэрээр/ Нүүрсний хэлтсээс авч дүгнэлт боловсруулан яамны удирдлагуудад танилцуулсан. Уул уурхайн сайдын /хуучин нэрээр/ Сангийн яам, Ашигт малтмалын газар /хуучин нэрээр/, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Монгол Нүүрс ассоциаци болон нүүрс экспортлогч аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй уулзах уулзалтыг 2 дугаар сард зохион байгуулж, холбогдох бэлтгэлийг ханган ажилласан. Тус уулзалтын хүрээнд нүүрсний экспортыг нэмэгдүүлэх боломжийн талаар санал боловсруулж хэлэлцүүлсэн. Түүнчлэн нүүрсний олон улсын зах зээлийн судалгаа, холбогдох танилцуулгыг боловсруулж, зах зээлийн үнэ, эрэлтийн талаарх мэдээллийг удирдлагуудад танилцуулсан.</p>	27	
<p>4.3.3. Уламжлалт бус эх үүсвэрээс /нүүрсний давхаргын метан, занар, байгалийн битум, тослог элс г.м/ байгаль орчинд ээлтэй шингэн болон хийн түлш боловсруулах асуудлаар мэргэжлийн төрийн болон судалгаа, шинжилгээний байгууллага, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын үүсгэл санаачилгыг дэмжинэ.</p> <p>- Нүүрсний давхаргын хий, шатдаг занарын эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.</p> <p>- Нүүрсний давхаргын хий ашиглах туршилт, судалгааны ажилд бодлогын дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Бодлогын дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: 4-р улирал</p>	<p>Шатдаг занарын 2, Нүүрсний давхаргын метан хийн 5, нийт уламжлалт бус газрын тосны 7 эрлийн гэрээ хэрэгжиж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Эрдэнэс таван толгой” ХК-2014.09.10 2. “Монголын алт” (МАК) ХХК-2014.09.10 3. “Эко Интернэшнл Энерги” ХХК-2014.11.30 4. “Хайланд Петролеум” ХХК-2014.11.24 5. “Петровис ресурс” ХХК-2015.03.30 6. “Петровис ресурс” ХХК-2015.10.20 7. “Жи Өү Эйч” ХХК (Golden horde) 2016.01.15 <p>Шатдаг занарын 2 эрлийн ажлын гэрээ хэрэгжиж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. “Дорны Хар Алт” ХХК-2012.08.28. 2. “Жени ойл шейл Монголиа” ХХК-2013.04.12 <p>Нүүрсний давхаргын метан хийн хайгуул, олборлолтын туршилт хийж буй “Эрдэнэс таван толгой”, “Кореа газ”, “Элгэн” ХХК-ийн туршилтын үйл ажиллагаанд ашиглах тусгай хийнд импортын тусгай зөвшөөрлийг олгов.</p>	27	
<p>5.0 ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХУВИЛБАР БОЛОВСРУУЛАХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:</p>			
<p>5.1. Хүнд үйлдвэрийн талаарх хуулт тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:</p>			
<p>5.1.1. Хүнд үйлдвэрийн талаарх хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөрийн төсөл боловсруулах</p> <p>- “Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтот хөтөлбөр” -ийн төсөл боловсруулж хэлэлцүүлнэ.</p> <p>- “Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг сэргээн хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.</p>	<p>“Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтот хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, яамны газар, хэлтсүүдээс санал авч нэгтгэх ажлыг зохион байгуулсан. Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг сэргээн хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, дууссан. Газар, хэлтсүүдээс санал авахаар бэлтгэж байна.</p>	15	

<p>5.1.3. Аж ахуйн үйл ажиллагааны тухай хууль болон Газрын тосны бүтээгдэхүүний хуулийн заалтыг хэрэгжүүлэх - Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах журмыг шинэчлэн батлуулж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Журам батлагдсан байна. Хугацаа: 12 сард</p>	<p>Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах журмыг боловсруулсан.</p>	<p>9</p>	
<p>5.1.4. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн орчныг сайжруулах - “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулсан байна. Хугацаа: 12 сард</p>	<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, паркийн нэгжүүдийн үйлдвэрлэлийг дэмжсэн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг боловсруулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн. Энэхүү ажлын хүрээнд дараах ажлууд хийгдэв.Үүнд: 1.Эрдэнэт, Дархан, Багануур, Баянговь үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлагуудаас хуулийн төсөлд санал авч, нэгтгэв. 2. 2016 оны 10 дугаар сарын 26-наас 11 дүгээр сарын 16-ны хооронд БНХАУ-ын хилийн чанад дахь аж үйлдвэрийн паркийн туршлагатай танилцаж, холбогдох судалгааг хийв. 3. БНХАУ-ын аж үйлдвэрийн паркийг хөгжүүлсэн туршлага болон судалгааны талаар 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр яамны ажилтнууд болон УТП-ийн удирдлагуудыг хамруулсан танилцуулга, нээлттэй хэлэлцүүлгийг хийв. 4. 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдөр хуулийн үзэл баримтлал болон төслийн анхны хэлэлцүүлгийг Паркийн удирдлагууд болон зарим төрийн бус байгууллагын хүрээнд зохион байгуулсан.</p>	<p>9</p>	
<p>5.2. Хүнд үйлдвэрийн салбарт хар ба өнгөт төмөрлөгийн болон машин байгууламж, металл хийцийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний сүлжээг бий болгох бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:</p>			
<p>5.2.4. Төмөрлөгийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх -Бүгд Найрамдах Чех Улсын техник, технологиор металлургийн коксын үйлдвэрийг барьж байгуулах ажлыг эрчимжүүлнэ. Тоо хэмжээ: 1, Чанар: Хөрөнгө оруулагчдад төслийг танилцуулсан байна. Хугацаа: 12 сард</p>	<p>Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар анхаарал тавьж ажиллаж байна. Коксын үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа Нью Эко Энержи компани нь БНЧех улсын Экспортын банкинд төслөө танилцуулж төслийн санхүүжилтын 80%-ийн хэмжээтэй зээл авах санал тавьсан.</p>	<p>15</p>	
<p>5.3. Газрын тос, уламжлалт бус газрын тос боловсруулах үйлдвэр, нүүрсийг хагас, гүн боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэр байгуулах, бүтээгдэхүүнийг дотоод, гадаад зах зээлд борлуулах бодлогын удирдамжаар хангах</p>			
<p>5.3.1. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах - "Газрын тос боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл"-ийг Засгийн газарт танилцуулж, үйлдвэр байгуулах хөрөнгө оруулалтын тендер, хувь эзэмшлийн талаар холбогдох шийдвэр гаргуулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. Хугацаа: 12 сард</p>	<p>"Газрын тос боловсруулах үйлдвэрийн асуудлыг Засгийн газарт 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр танилцуулсан. Засгийн газрын хуралдаанаас үйлдвэр байгуулах хөрөнгө оруулалтын асуудлыг тодорхой болгож танилцуулахыг Сангийн яаманд үүрэг болгосны дагуу 2016 оны талаар 12 дугаар сарын 14-ний өдөр Засгийн газрын хуралдаанд дахин хэлэлцүүлэв. Засгийн газрын хуралдаанаас Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг санхүүжүүлэх шийдвэр гаргав.</p>	<p>30</p>	
<p>5.3.3. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэлээр Улаанбаатар хотын захиргаатай хамтран ажиллах</p>	<p>Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэлээр Улаанбаатар хотын Удирдлагуудтай 11 дүгээр сарын 4-ний өдөр уулзалт зохион</p>	<p>30</p>	

<p>- Хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох уулзалтыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Уулзалт зохион байгуулсан байна. Хугацаа: 11 сард</p>	<p>байгуулж, төслийн талаар танилцуулга хийж, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд хамтран ажиллахаар тохиролцсон.</p>			
<p>6.0. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОХИЦУУЛАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:</p>				
<p>6.1. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах гол зорилтын хүрээнд:</p>				
<p>6.1.1. Засгийн газраас баталсан хил хязгаарын дагуу хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллана. - “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтийн талаар Удирдлагыг мэдээллээр хангаж ажиллана. Тоо хэмжээ: 4 удаа, Чанар: Мэдээлэл бодит, үндэслэлтэй тоо баримттай байна. Хугацаа: Улирал бүр</p>		<p>“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтийн талаар Удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллаж байна.</p>	<p>27</p>	
<p>6.1.2. Ашигт малтмалын тухай хуулийн 35.4 дүгээрт гэж заасны дагуу үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болсон уурхай, уулын үйлдвэрүүдийг ашиглалтад хүлээн авна. - Уурхай, уулын үйлдвэр хүлээлгэн өгөх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг судлан үзэж хариу өгнө. - Баримт бичгийн бүрдэл хангасан аж ахуйн нэгжүүдийн уурхай, уулын үйлдвэрт Техникийн болон Улсын комисст ажиллна. Тоо хэмжээ: 1удаа, Чанар: Хүсэлтүүдийг судалж, хариу өгсөн байна. Хугацаа: Тухай бүр</p>	<p>Уурхай, баяжуулах үйлдвэрийг Улсын комисс ажиллуулан ашиглалтанд хүлээлгэж өгөхөөр 2016 онд нийт 47 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлсэн. Комисс ажлууллагаар хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй холбоо тогтоож бичиг баримтын бүрдэл хангасан 21 уурхайд Улсын комисс ажилласан, бичиг баримтын бүрдэл хангалттай-5, бичиг баримтын бүрдэл хангаагүй-18, бичиг баримтын бүрдэлээ ирүүлээгүй-3 аж ахуйн нэгж байна. Уурхай, уулын үйлдвэр, баяжуулах үйлдвэр байнгын үйл ажиллагаанд хүлээн авах Улсын комисс 21 уурхайг цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг өгч, хүлээн авсан.</p>		<p>30</p>	
<p>6.1.3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлнэ. - Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах, ажил үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн материалыг судалж санал боловсруулна. - Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын аюулгүйн бүс тогтоолгох хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг судалж санал боловсруулна. - Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн импортын тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн материалыг судалж санал боловсруулна. - Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих Мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Хуульд нийцсэн байна. Хугацаа: Тухай бүр</p>		<p>Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах, ажил үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл хүссэн 12 аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл олгосон. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын аюулгүйн бүс тогтоолгох хүсэлт ирүүлсэн 29аж ахуйн нэгжүүдэд аюулгүйн бүс тогтоох комисс ажилласан. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн импортын тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжид 22 импортын лиценз шинээр олгож, 8 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан. Уул уурхайн сайдын 2015 оны 101 тоот тушаалаар байгуулагдсан “Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг шинэчлэн боловсруулах” үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих Мэргэжлийн зөвлөлийн 6 удаагийн хуралдааныг зохион байгуулж, 5 аж ахуйн нэгжийн асуудлыг шийдвэрлэсэн.</p>	<p>30</p>	

<p>6.1.5. Гурванбулаг, Дорнод, Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийт, Дулаан-Уул, Зөөвч овоо ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна.</p> <p>- Гурванбулаг, Дорнод, Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийт, Дулаан-Уул, Зөөвч овоо ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй яриа хэлэлцээрийг эхлүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар:Судалгаа хийсэн байна. Хугацаа: 4 улиралд</p>	<p>Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийтийн ураны ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлын хүрээнд тэдгээр ордуудыг худалдан авагчийн талын буюу Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ивана Гроллоовой Уул уурхайн сайд Р.Жигжидтэй хийсэн ажил хэргийн уулзалтанд оролцож цаашдын үйл ажиллагааны талаар санал өгч ажилласан болно.</p> <p>Дулаан-Уул, Зөөвч овоо ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын хүрээнд Арева Монгол ХХК, Арева групп, Мицубиши групп, Франц улсаас Монгол улсад суугаа элчин сайд, Францын Санхүү эдийн засгийн яамны төлөөлөгч гэх мэт холбогдох удирдлагууд болон албан тушаалтнуудтай удирдлагуудын хүрээний албан уулзалт 6 удаа, ажлын хэсгийн болон уулзалтын хэрэгжилтийн хүрээнд нийт 9 удаа уулзаж төслүүдийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх чиглэлээр ярилцан тохиролцох, санал солилцох зорилготойгоор уулзалтуудыг зохион байгуулж оролцож ажилласан.</p>	15	
<p>6.1.6. Цацраг идэвхт ашигт малтмалын орд газруудыг түшиглэн Дорноговь, Дундговь, Дорнод аймгуудад боловсруулах үйлдвэр барьж байгуулах ажлыг зохион байгуулна.</p> <p>- Цацраг идэвхт ашигт малтмалын орд газруудыг түшиглэн Дорноговь, Дундговь, Дорнод аймгуудад боловсруулах үйлдвэр барьж байгуулах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах талаар Олон Улсын байгууллагуудад хандана. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Тодорхой санал гарсан байна. Хугацаа: 4 улиралд</p>	<p>Энэхүү ажил нь цаг хугацаа, үйл ажиллагааны хувьд одоогоор арай бэлэн болоогүй боловч орд газруудыг ашиглах ордыг эзэмшигчдээс урьдчилсан саналыг хүлээн аваад байгаа болно. Мөн боловсруулах үйлдвэр барьж байгуулах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах талаар төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд мөн ажил үүргийн чиг үүрэг өөрчлөгдсөнөөр Хүнд үйлдвэрийн газарт боловсруулах үйлдвэрийг холбоотой асуудлыг шилжүүлж байна.</p>	21	
<p>6.1.7. Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэж, олон улсын жишигт хүрсэн, стандартын шаардлагад нийцсэн, үндэсний мэдээллийн санг бүрдүүлнэ.</p> <p>Цацраг идэвхт ашигт малтмалын ордын нөөцийг Үндэсний геологийн мэдээллийн санд бүртгүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар:Нөөц бүртгэгдсэн байна. Хугацаа: 4 улиралд</p>	<p>Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр 13 аж ахуйн нэгж 46 тусгай зөвшөөрөл дээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жил бүрийн хайгуулын ажлын тайлан төлөвлөгөөг боловсруулан аймаг орон нутаг, геологи уул уурхайн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын төрийн захиргааны байгууллагуудаар тодорхой хяналт шалгалтанд хамрагдаж батлуулж хүлээлгэн өгдөг бөгөөд тэдгээр геологи хайгуулын ажлын мэдээ мэдээллийг Ашигт малтмалын газар хүлээн авч Геологийн албандаа мэдээллийн санд нэтгэж бүртгэн хүлээн авч геологи хайгуулын ажлын мэдээллийн санг бүрдүүлж байна. Энэхүү ажилд хяналт тавьж мэдээ мэдээллийг тухай бүрт нь хүлээн авч Уул уурхайн сайд, төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газарт шаардлагатай үед нь мэдээлж ажилласан болно.</p>	15	
<p>6.2. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг гэрээ хэлцэлд бэлтгэх, хэрэгжилтийг зохицуулах гол зорилтын хүрээнд:</p>			
<p>6.2.1. Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг уурхайг түшиглэн цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийнэ.</p>	<p>“Шивээ-Овоо” ХХК болон “Эрдэнэс Монгол” ХХК хамтран “Шинэ шивээ” төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд Хятадын “Стэйд грөйд” компанитай хамтран нийт 1,5</p>	21	

<p>Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан станц, эрчим хүчний цогцолборыг нүүрсээр хангах асуудлыг шийдвэрлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.</p> <p>Тоо хэмжээ: 1, Чанар: Судалгаа хийгдсэн байна. Хугацаа: 4 улиралд</p>	<p>тэрбум.тн нөөцтэй орд ашиглах ТЭЗҮ боловсруулж байна.</p>		
<p>6.3. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн бодлого, улсын төсөв, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулалтаар хангах гол зорилтын хүрээнд:</p>			
<p>6.3.3. Монгол орны геологийн тогтоц, ашигт малтмалын ерөнхий тархалтыг сансрын зураг ашиглан нэгдсэн боловсруулалт, тайлалт хийнэ.</p> <p>- Төслийн 2016 оны судалгааны ажлын төсөл, төсвийн тодотголыг хянах, хээрийн ажлын явцад шуурхай хяналт хийнэ.</p> <p>- Төслийн 2016 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн болон анхдагч баримт материалыг хүлээн авна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Хээрийн материалыг хүлээн авсан байна. Хугацаа:11-12-р сар</p>	<p>Төслийн ажлын 2016 оны ажлын арга аргачлал, хэмжээ, түүнтэй уялдан гарах төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн.</p> <p>Ажлын хэсэг ажиллаж, 2016 оны суурин боловсруулалтын ажилтай танилцаж, анхдагч баримт материалыг хүлээн авсан.</p>	<p>27</p>	
<p>6.3.4. Умарт мөсөн далайгаас Гималайн нуруу хүртэл Ази тивийн хэмжээнд хийсэн геологийн төрөл бүрийн судалгааны үр дүнг нэгтгэн, ОХУ, БНХАУ, БНКаЗУ, БНСУ-тай хамтран төрөлжсөн зургийг тайлбар зургийн хамт зохиох, сонирхол бүхий бүтцийн хэмжээнд 3D хэмжээст судалгаа хийх, мэдээлэл харилцан солилцох, харьцуулах, нэгтгэх ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>- Төслийн 2016 оны судалгааны ажлын төсөл, төсвийн тодотголыг хянах, хээрийн ажлын явцад шуурхай хяналт хийнэ.</p> <p>- Төслийн 2016 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн болон анхдагч баримт материалыг хүлээн авна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Хээрийн материалыг хүлээн авсан байна. Хугацаа: 3-4-р улирал</p>	<p>Төслийн ажлын 2016 оны ажлын арга аргачлал, хэмжээ, түүнтэй уялдан гарах төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн.</p> <p>Ажлын хэсэг ажиллаж, 2016 оны суурин боловсруулалтын ажилтай танилцаж, анхдагч баримт материалыг хүлээн авсан.</p>	<p>27</p>	
<p>6.3.5. Монгол орны бүс нутгийн металлогени, ашигт малтмалын ордын төрлүүдийн тархан байршлын зүй тогтлын 1:1000000-ны масштабын зураг зохионо.</p> <p>- Төслийн 2016 оны судалгааны ажлын төсөл, төсвийн тодотголыг хянах, хээрийн ажлын явцад шуурхай хяналт хийнэ.</p> <p>- Төслийн 2016 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн болон анхдагч баримт материалыг хүлээн авна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Бүрэн хүлээн авсан байна. Хугацаа:11-12-р сар</p>	<p>Монгол орны бүс нутгийн металлогений 1:1000000-ны масштабын зураг зохиох төслийн арга, аргачлал, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн.</p> <p>Шуурхай хяналт хийсэн.</p> <p>Ажлын хэсэг ажиллаж, 2016 оны суурин боловсруулалтын ажилтай танилцаж, анхдагч баримт материалыг хүлээн авсан.</p>	<p>27</p>	
<p>6.3.7. Геологийн судалгаа, хайгуулын ажлын үр дүнг нэгтгэн боловсруулж, үндэсний геомэдээллийн санг баяжуулна. Мэдээлэл түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгоно.</p> <p>- Төслийн 2016 оны судалгааны ажлын төсөл, төсвийн тодотголыг хянах, хээрийн ажлын явцад шуурхай хяналт хийнэ.</p> <p>- Төслийн 2016 онд гүйцэтгэх судалгааны ажлын үр дүн болон анхдагч баримт материалыг хүлээн авахад оролцно.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Бүрэн хүлээн авсан байна. Хугацаа:11-12-р сар</p>	<p>Улсын төсдийн хөрөнгөөр 2016 онд гүйцэтгэсэн төслүүдийн хээрийн судалгааны ажлын явц улиралын тайлан болон түүнд АМГТГ-аас хийсэн хээрийн шуурхай хяналтын илтгэх хуудас болон бусад баримт материалуудтай танилцаж, хянасан.</p> <p>Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлсэн судалгааны ажлуудын хээрийн болон анхдагч баримт материалуудыг хүлээн авах хуваарь , хүлээн авсан тухай илтгэх хуудас бусад материалуудтай танилцаж хянасан.</p>	<p>27</p>	

<p>6.3.8. Монгол орны баруун бүсэд цул сульфидын хүдэржилтийн тархалтыг 1:1000000-ын масштабын хэтийн төлөвийн зураг зохиох, үнэлгээ өгөх, цаашдын судалгааны объектыг тодруулах төсөл хэрэгжүүлнэ.</p> <p>- Төслийн 2016 оны судалгааны ажлын төсөл, төсвийн тодотголыг хянах, хээрийн ажлын явцад шуурхай хяналт хийнэ.</p> <p>- Төслийн 2016 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн болон анхдагч баримт материалыг хүлээн авахад оролцоно.</p> <p>Тоо хэмжээ: 1, Чанар: Бүрэн хүлээн авсан байна. Хугацаа:11-12-р сар</p>	<p>Монгол орны баруун бүсэд цул сульфидын хүдэржилтийн тархалт, хэтийн төлөвийн 1:1000000-ын масштабын зураг зохиох, үнэлгээ өгөх, цаашдын судалгааны объектыг тодруулах ажлын төсөл, төсвийг УУХҮС-ын 2016 оны 31 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцэж баталсан. Төслийн хээрийн судалгааны ажлын анхдагч баримт материалыг хүлээн авсан тухай илтгэх хуудас болон бусад баримт материалтай танилцаж, хянасан.</p>	21	
<p>6.3.9. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.</p> <p>- “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулна.</p> <p>- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд нэмэлт өөрчлөлт оруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ.</p> <p>- Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 Чанар: Хуульд нийцсэн Хугацаа: 4 улиралд</p>	<p>“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах Сайдын 2015.02.25-ны 34 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хүрээнд журмын төслийг шинэчлэн боловсруулсан.</p> <p>МөнБичил уурхайг хууль, журмын хүрээнд зохион байгуулалтад оруулж, албажуулснаар бичил уурхайн салбарын орон нутгийн болон Монгол улсын эдийн засагт оруулах хувь нэмэр, ач холбогдлыг дээшлүүлэх боломжийн талаар оролцогч талуудыг мэдээллээр хангах, хариуцлагатай бичил уурхайн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Бичил уурхайг албажуулах замаар эдийн засагт оруулах хувь нэмрийг дээшлүүлэх нь” сэдэвт 3 бүсийн чуулганыг 2016.11.16-17-ны өдрүүдэд Ховд, Хэнтий, Өвөрхангай аймгийн төвд амжилттай зохион байгуулсан. Гурван бүсийн чуулганд 18 аймаг, 84 сумын Засаг дарга, ИТХ-ын дарга нар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нар болон холбогдох албан тушаалтнууд болон бичил уурхайчдын төлөөлөл нийт 470 гаруй хүн оролцсон.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар, Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) хамтран “Бичил уурхайг албажуулахад талуудын оролцоо” сэдэвт үндэсний чуулганыг 2016 оны 12 сарын 7-ны өдөр Чингис зочид буудалд зохион байгуулсан.</p>	21	
<p>6.4. Салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах гол зорилтын хүрээнд:</p>			
<p>6.4.1. Геологи, уул уурхайн салбараас улсын төсөв, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх, эрдсийн бүтээгдэхүүний үнэ, эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийнэ.</p> <p>- Уурхай, үйлдвэрүүдийн эрдэст бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийж зөвлөмж, дүгнэлт гаргана.</p> <p>- Уул уурхайн боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн хангамжийн талаар санал боловсруулна.</p> <p>- Уул уурхайн гаралтай эрдэс, түүхий эд, баяжмал бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ тогтоох судалгаа хийж, дүгнэлт гаргана.</p> <p>Тоо хэмжээ: 1 Чанар: Санал зөвлөмж гарсан байна. Хугацаа: 4 улиралд</p>	<p>Сангийн яам, Татварын ерөнхий газар, АМГТГ-аас ирүүлсэн мэдээ тайланг нэгтгэн, яамны бодлогын газруудыг тоон мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн бүртгэлийн ажлыг яамны бусад газруудтай хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.</p> <p>Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 10 сарын 24-ний өдрийн хамтарсан 358/А45 тоот тушаалаар батлагдсан байнгын ажиллагаатай Ажлын хэсэгт ажиллаж байна.</p>	3	
